



АЛЬФА СКАЙ БЮЛДИНГ ХХК-Н  
ЗАХИРГААНД

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР**  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН ДУГНЭЛТ

Нийслэлийн засаг захиргааны III байр,  
Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: (976) 7777-5000, Факс: (976) 7777-5120  
Цахим шуудан: ub\_info@inspection.gov.mn  
Цахим хуудас: www.ub.inspection.gov.mn

2022.11.03 № 02-03-317/1068  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Зураг төсөлд эрүүл ахуйн хяналт  
хийсэн тухай

Танай компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 4.1 дэх хэсэг, 2021 оны А/57 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг өөрчлөхөд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж, дүгнэлт гаргах заавар”. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын тэргүүн дэд даргын баталсан 01/16 дугаартай удирдамжийг тус тус үндэслэн Эрүүл ахуй халдварт хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч М.Нэргүй би 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах 74 дүгээр цэцэрлэгийн барилгын зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлзээ.

Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, зураг төслийн нэр, үе шат:

Нийслэлийн ерөнхий архитекторын баталсан 2022 оны БХБХ2022/01-050 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавартай. Ерөнхий төлөвлөгөө, барилга архитектур, барилга бүтээц, дотор халаалт, агаар сэлгэлт, цэвэр, бохир ус гэсэн иж бүрэн ажлын зургийг “Альфа скай бюлдинг” ХХК-д 2022 онд боловсруулсан.ЕТ, БА, ББ зургийн шифр S and B-C2-2022.

Барилга байгууламж барих газрын зөвшөөрөл:

Чингэлтэй дүүргийн 74 дүгээр цэцэрлэгт тус дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт боловсролын байгууллагын зориулалтаар 5184 м.кв газрыг олгосон Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн 0000121048 дугаартай гэрчилгээтэй.

Зураг төслийн товч агуулга:

Цэцэрлэгийн барилга хагас зоорьтой 2 давхар, төмөр бетон каркасан рамтай. Хуучин цэцэрлэгийн эдэлбэр газрын ногоон байгууламжийг сэргээж, хүүхдийн тоглоомын талбайг хөдөлгөөнт тоглоом тавьж тохижуулахаар төлөвлөсөн.

115050025230

Цэцэрлэгийн барилгын зоорийн давхарт шатны хонгил, вестибюль, багш хөгжлийн төв, заал, цагаан хэрэглэл угаалга, хатаалгын өрөө, сан цахилгаан, холбооны техникийн өрөөнүүд төлөвлөсөн;

1-р давхарт гонх, коридор, шатны хонгил, гадагш гарах хаалгатай тусгаарлах өрөө, ариун цэврийн өрөөтэй эмчийн өрөө, тус давхарт 5 ангитай, анги бүр 36 -45м.кв унтлагын өрөө, 66-78 м.кв талбайтай бүлгийн өрөө, тус бүр ор хураах өрөө, ариун цэврийн өрөө, хүлээн авахтай, 1 ангид 20-25 хүүхэд авахаар төлөвлөсөн, гаднаас орох хаалгатай, ажилчдын хувцас солих, ариун цэврийн өрөөтэй, 2 агуулах, бэлтгэл, угаалга, халуун боловсруулалтын өрөөтэй гал тогоо, ажилчдын ариун цэврийн өрөө төлөвлөсөн;

2-р давхарт 5 ангитай, анги бүр 36-45м.кв унтлагын өрөө, 66-78 м.кв талбайтай бүлгийн өрөө, тус бүр ор хураах өрөө, ариун цэврийн өрөө, хүлээн авахтай, 1 ангид 20-25 хүүхэд авахаар төлөвлөсөн, агуулах бүхий 66.7 м.кв урлаг заал эрхлэгч, нягтлан, арга зүйчийн өрөө, ажилчдын ариун цэврийн өрөөтэй төлөвлөсөн байна.

Ус хангамж: Ус сувгийн удирдах газрын 2 022 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн №469/22 дугаартай техникийн нөхцөлтэй. "УБЦТС" ТӨХК-н 15/03346/22 техникийн нөхцөлтэй.

Дулаан хангамж: "УБДС" ТӨХК-ийн 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн №232/2022 дугаартай техникийн нөхцөлтэй.

Агаар сэлгэлт: Барилгын агаар сэлгэлтийн агаар оруулах, соруулах механик системийг цагаан хэрэглэл угаалга, спорт заал, хоол үйлдвэрлэлийн өрөөнд, бусад өрөө тасалгаанд ердийн систем төлөвлөсөн.

Инженер геологийн судалгааны талаар:

"Аварга геопроект" ХХК-ийн 2022 онд хийсэн инженер геологийн судалгаагаар барилга барихаар сонгосон талбай төвөгтэй нөхцөлтэй хөрсний ус 4.0м-ээс илэрсэн байна. Судалгаагаар барилгыг гадаргуугийн болон хөрсний уснаас хамгаалах арга хэмжээг тооцох, суурин котлованийг нээсний дараа хяналт хийлгэх шаардлагатай. /3T12-1311/18/

ДҮГНЭХ НЬ:

Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах 74 дүгээр цэцэрлэгийн барилгын ажлын зургийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2021 оны А/57 дугаар тушаалаар батлагдсан зааврын дагуу хянахад Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03 стандартын эрүүл ахуйн холбогдох шаардлагад нийцэж байна.

Улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг үндэслэн гомдол гаргах эрхтэй.

ЭРҮҮЛ АХУЙ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ М.НЭРГҮЙ

ЗАХИРАЛ

В.БААСАНБААТАР

